



МОНГОЛ УЛС
ХОВД АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2021 оны 07 сарын 29 өдөр

Дугаар А/372

Ховд

Хөрөнгө гаргах тухай

Төсвийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.2.3, 41 дүгээр зүйлийн 41.2.2, Хүүхэд хамгааллын тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.1 дэх заалт, аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2020 оны 03/03 тоот тогтоолыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Уралдаанч хүүхдийн стандартын хамгаалалтын иж бүрэн хувцас, хэрэглэлийг жишиг болгож хэвшүүлэх, хүүхдийн аюулгүй байдлыг хангах, эрсдлээс хамгаалах зорилгоор хамгаалалтын 40 ширхэг хувцас худалдан авах зардалд 5 200 000 төгрөг, тээврийн зардалд 120 000 төгрөг нийт 5 320 000 төгрөгийг хавсралтаар баталж, зарцуулсугай.

2. Зардалд зарцуулагдах 5 320 000 төгрөг /Таван сая гурван зуун хорин мянга/-ийг Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөр 2021 онд хэрэгжүүлэх хөрөнгө оруулалт, хөтөлбөр, төсөл арга хэмжээний 4.4 дэх "Спортын аварга" хөтөлбөр, төслөөс тооцож гаргахыг аймгийн Санхүү, төрийн сангийн хэлтсийн дарга /Ч.Багдал/-д зөвшөөрсүгэй.


3. Захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг аймгийн Аймгийн Засаг даргын орлогч /Т.Дэлгэрсайхан/-д даалгасугай.

ЗАСАГ ДАРГА



Б.ДҮГЭРЖАВ

Аймгийн Засаг даргын 2021 оны
07 дугаар сарын 29-ний өдрийн
А/372 дугаар захирамжийн хавсралт



ХАМГААЛАЛТЫН ХУВЦАС ХУДАЛДАН АВАХ ЗАРДЛЫН ТООЦОО

дд	Материалын нэр	Тоо ширхэг	Нэгж үнэ	Нийт үнэ
1	Хамгаалалтын иж бүрэн хувцас	40	130000	5200000
2	Тээврийн зардал	1	120000	120000
Нийт дүн				5320000

-oOo-